МЭДЭЭ · 2023 оны 8-р сарын 18

ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ҮЙЛДЭГДСЭН 11 ХЭРЭГТ ЯЛЛАХ ДҮГНЭЛТ ҮЙЛДЭН ШҮҮХЭД ШИЛЖҮҮЛЛЭЭ



Улсын ерөнхий прокурор хүний эрх, эрх чөлөө, өмчлөх эрхийг хамгаалах, гэмт үйлдлийг таслан зогсоох, зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор зохион байгуулалттай бүлэг этгээдийн үйлдсэн бусдын эд хөрөнгийг авахаар хүч хэрэглэсэн, заналхийлсэн гэмт хэргийг шалгаж, шийдвэрлэх ажлын хэсгийг байгуулсан талаар өмнө нь мэдээлсэн. **/Энд дарж үзнэ үү/**

Ажлын хэсэг байгуулагдсанаас хойшхи хугацаанд Цагдаагийн байгууллагаас хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж буй, зохион байгуулалттай үйлдэгдсэн гэх 26 хэргийг прокурор хянаад, гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх үндэслэл, нөхцөл байдал тогтоогдсон 15 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн, 57 хүнийг яллагдагчаар татан, мөрдөн байцаалтад шилжүүлсэн байна.

Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татагдсан 57 хүний 3 нь гадаад улсын иргэн бол 21 нь хувийн компанийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан, 36 нь эрхэлсэн

тодорхой ажилгүй иргэд байна.

Ажлын хэсгээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан 52 хүнд холбогдох 11 хэрэгт яллах дүгнэлт үйлдэн шүүхэд шилжүүлээд байна.

Тухайлбал, “Хамаг Монгол” ТББ-ын тэргүүн Н.Х нь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдлага болох БНХАУ-ын иргэнийг айлган сүрдүүлж, 11 сая төгрөгийг шилжүүлэн авсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 17.6 дугаар зүйлийн 1 /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх/-т зааснаар;

- Иргэн Д.Б, А.Д, Ц.М, Т.Х нар Монгол Улсын иргэн П.О, Ч.Б болон БНХАУ-ын иргэн Б.Э нарын захиалгаар БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Ш” ХХК-ийн захирал БНХАУ-ын иргэн В-г Монгол Улсын Засгийн газартай байгуулсан концессын гэрээнээс татгалзуулах зорилгоор айлган сүрдүүлж, хүч хэрэглэн, хуурамч албан бичиг дээр гарын үсэг зуруулж, эд хөрөнгийн эрхээ шилжүүлэхийг шаардсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 17.6 дугаар зүйлийн 2.3 /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх/-т зааснаар;

- Иргэн М.А нь Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт “Ю” ХХК-ийн дэд захирал А.Г, ажилтан Ц.Б нарт хүч хэрэглэх, хутга тулгах зэргээр айлган сүрдүүлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулахад саад учруулах зэргээр заналхийлж, 10,000,000 төгрөгийг шилжүүлэн авсан гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 17.6 дугаар зүйлийн 1 /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх/-т зааснаар;

- Иргэн Л.А, Б.Х, Б.У нарын 16 хүн зохион байгуулалттай гэмт бүлэглэл байгуулж, бусдын эд хөрөнгийг авахаар айлган сүрдүүлж заналхийлэх, хүчиндэх, эрүүл мэндэд хохирол учруулах, олон нийтийн хэв журмыг зөрчиж, танхайрах гэх хэрэгт Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.4 /Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 11.6 дугаар зүйлийн 1 /Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах/, 12.1 дүгээр зүйлийн 2,2, 2.10 /Хүчиндэх/, 17.6 дугаар зүйлийн 2.3 /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх/, 20.3 дугаар зүйлийн 1, 2 /Зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд элсэх/, 20.16 дугаар зүйлийн 1, 2.1 /Олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулах/-т зааснаар яллах дүгнэлт үйлдэн, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/1603